



**МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 12 сарын 30 өдөр

Дугаар A/310

Улаанбаатар хот

**Мал эмнэлгийн лабораторийн үндэсний
сүлжээг хөгжүүлэх богино болон дунд хугацааны
стратеги батлах тухай**

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4 дэх хэсэг, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Монгол улсын мал эмнэлгийн лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлэх богино болон дунд хугацааны стратегийг хавсралтаар баталсугай.
2. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан, үр дүнтэй зохион байгуулж, ажлын уялдаа холбоогоор хангахыг Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори /Т.Тунгалаг/-д үүрэг болгосугай.
3. Стратегийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд шаардагдах зардлыг жил бүрийн төсөв, олон улсын төсөл, хөтөлбөрт тусган, холбогдох хууль, журмын дагуу хяналт тавьж ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын газар /Л.Гандолгор/-т зөвшөөрсүгэй.
4. Стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, үнэлгээг жил бүр хийж үр дүнг Мэргэжлийн зөвлөлийн хуралд танилцуулахыг Мал эмнэлгийн хяналт, эрсдэлийн үнэлгээний газар /Б.Болдбаатар/-т даалгасугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ГАНЗОРИГ

Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын
2021 оны 12 дугаар сарын ...-ны
өдрийн ... дугаар тушаалын
хавсралт



МОНГОЛ УЛСЫН МАЛ ЭМНЭЛГИЙН ЛАБОРАТОРИЙН ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭГ
ХӨГЖҮҮЛЭХ БОГИНО БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ СТРАТЕГИ
(2021- 2030 он)

Энэхүү баримт бичигт сум, аймаг, нийслэл, улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн төрийн өмчийн лабораторийг хөгжүүлэх, үйл ажиллагааны уялдаа холбоог сайжруулах зорилгоор ойрын таван жилийн хугацаанд болон 2030 он хүртэлх дунд хугацаанд хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, тавьсан зорилтыг тодорхойлов. Мал эмнэлгийн бүх шатны лабораторид хөрөнгө оруулалт хийх, төрөл бүрийн хэлбэрээр дэмжлэг үзүүлэх, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үйл ажиллагааны жилийн төлөвлөлт хийхэд энэхүү стратегийг үндэслэл болгоно.

Улаанбаатар
2021 он

АГУУЛГА

НЭГ. ҮНДЭСЛЭЛ	4
ХОЁР. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ	7
ГУРАВ. АЛСЫН ХАРАА	7
ДӨРӨВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО	7
ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН	7
ЗУРГАА. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ:	8
ДОЛОО. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ, ОЙЛГОЛТ	9
НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН: (ТӨЛӨВЛӨЛТИЙН МАТРИЦ)	11
ЕС. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА БА ТАКТИК	25
АРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ	26

Товчилсон үгийн тайлал:

АС (ЭК)	Агааржуулалт (Эйр кондишининг)
АМЭЛ	Аймгийн мал эмнэлгийн лаборатори
БАБ	Био-аюулгүй байдал
ДМАЭМБ	Дэлхийн мал, амьтдын эрүүл мэндийн байгууллага
ДМАЭММС	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн мэдээллийн систем
ДСБЭ	Давуу ба сул талууд, боломж ба эрсдэл
ЗГХА	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг
ЛЗД	Лабораторийн зохистой дадал
ЛММС	Лабораторийн мэдээллийн менежментийн систем
ЛҮА	Лаборатори үнэлэх арга
МАНЭЗЭН	Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх
МЭЕГ	Мал эмнэлгийн ерөнхий газар
МЭЛ	Мал эмнэлгийн лаборатори
МЭЛС	Мал эмнэлгийн лабораторийн сүлжээ
МЭЭСБУЛ	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори
НМЭЛ	Нийслэлийн мал эмнэлгийн лаборатори
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ПГУ	Полимеразын гинжин урвал
САЗ	Стандарт ажлын заавар
ТХХТ	Төрийн болон хувийн хэвшлийн түншлэл
УМЭАЦТЛ	Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори
ХААИС	Хөдөө аж ахуйн их сургууль
ХХААБ	Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага
ХХААХҮ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ЧБ	Чанарын баталгаажуулалт
ЧХ	Чанарын хяналт

НЭГ. ҮНДЭСЛЭЛ

Монгол улсын Их хурлаас Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2017 оны 12 дугаар сард соёрхон баталж, 2018 оны 7 дугаар сарын 1-ээс мөрдөн ажиллаж байна. Энэхүү хуулийн хүрээнд Засгийн газрын 2018 оны 186 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МЭЕГ-ыг байгуулж, 188 дугаар тогтоолоор УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ-ийг МЭЕГ-ын харьяанд ажиллуулахаар шийдвэрлэж, 267 дугаар тогтоолоор аймаг, нийслэлийн Мал эмнэлгийн газар, сум дүүргийн Мал эмнэлгийн тасгийг байгуулж, Монгол улсын Мал эмнэлгийн байгууллага нэгдсэн бүтэц, тогтолцоонд шилжин ажиллаж байгаа билээ. Түүнчлэн ХХААХҮ-ийн сайдын 2020 оны А/303 дугаар тушаалаар "Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам"-ыг батлан хэрэгжүүлж байна.

Монгол улсын Мал эмнэлгийн байгууллага олон улсын жишигт нийцэн шинэ бүтэц тогтолцоо, шинэ хууль эрх зүйн орчинд шилжин ажиллаж буй энэ үед улс, аймаг нийслэл, сум дүүргийн мал эмнэлгийн лабораториудыг нэгдсэн бодлого төлөвлөгөөтэйгөөр сүлжээ байдлаар ажиллуулж, хамтад нь хөгжүүлэх, цаашилбал хүнсний зах, худалдааны төв, үйлдвэрийн дэргэдэх хувийн хэвшлийн мал эмнэлгийн лабораториудыг энэхүү сүлжээнд нэгтгэн хууль эрх зүйн хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хянах, дэмжиж ажиллах зайлшгүй шаардлага тулгарч байна.

Монгол улсын МАА-н салбарт хэрэгжиж буй Дэлхийн банкны "Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх" (МААЭЗЭН) төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлж, НҮБ-ын ХХААБ-ын "Лабораторийн үнэлгээний арга"(ЛҮА-ЛМТ)-аар Мал эмнэлгийн үндэсний 3 лаборатори, бүсийн 2 лаборатори, аймгийн 6 лаборатори, нийт 11 мал эмнэлгийн лабораторид 2021 оны 1-3 дугаар сард төслийн үндэсний зөвлөх, олон улсын шинжээчдийн дэмжлэгтэйгээр үнэлгээ хийж, зарим сум, дүүргийн лабораториудын нөхцөл байдлын талаар асуумж судалгаа авчээ.

Үнэлгээнд хамрагдсан 11 МЭЛ-ийн өнөөгийн чадавх буюу үйл ажиллагааны ерөнхий түвшин 33.2% байна. УМЭАЦТЛ (51.5%), МЭЭСБУЛ (36.1%), Хэнтий (35.3%), Сэлэнгэ (40.1%), аймгийн мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаа дунд зэргийн түвшинд (33 - 51.5%), бусад лабораториуд оношилгооны суурь түвшин (26.5 – 32.7%-д байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

1.1. Аймгуудын МЭЛ-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өнөөгийн байдал

Аймгуудын МЭЛ-ийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн өнөөгийн байдлын судалгааны дэлгэрэнгүй мэдээллийг 1-р хавсралтаар харуулав. Архангай, Өмнөговь аймгийн МЭЛ-уд 2020 онд шинэ барилгатай болсон. Дорноговь, Сэлэнгэ аймгийн МЭЛ-ийн барилгыг Азийн хөгжлийн банкны санхүүжилттэйгээр шинээр барьж байгаа. Одоогийн байдлаар Орхон, Говь-Сүмбэр, Увс, Дархан-Уул аймгийн МЭЛ өөрийн байр байхгүй, түрээсэлдэг.

Булган, Хөвсгөл аймгийн МЭЛ-дийг цаашид ашиглах боломжгүй тухай мэргэжлийн хяналтын байцаагчийн дүгнэлт, Булган аймгийн МЭЛ-т хүний эрх зөрчигдөж байгаа тухай шаардлага гарсан байдаг. Тухайлбал: Булган аймгийн МЭЛ-ийн ажлын байранд суурилуулсан агааржуулалтын системийн хүчин чадлыг сайжруулан эрүүл ахуй, инженер техник, технологи, зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Булган аймгийн мэргэжлийн хяналтын газрын хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлтдээ дурджээ. Бүгд найрамдах Чех улсаас хэрэгжүүлсэн "Хөгжлийн тусламжийн хамтын ажиллагааны хөтөлбөр"-өөр "Экологийн хуучин бохирдлыг арилгахад Ноу-хау технологи нэвтрүүлэх 2-р шатны төсөл"-ийн хүрээнд Булган орчмын эрсдэлийн шинжилгээ хийхэд Мал эмнэлгийн газарт пестицидүүдийг өмнө нь хангалтгүй хадгалснаас газрын хөрсөнд үлдэгдлийн голомт үүссэн, хөрсөнд агуулагдах хэмжээ нь хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс хэд дахин илүү байсан тухай тайланд мөн дурджээ. Түүнчлэн МЭЛ-т ашиглаж байсан химийн бодисыг устгах эрх зүйн зохицуулалт байхгүй гэх шалтгаанаар 1960-1970-аад оны үед хуучин социалист орнуудын тусламжтайгаар нийлүүлсэн 94 нэр төрлийн хуурай болон шингэн химийн бодисыг байрны доорх зоорины давхарт хадгалж байснаас тус газрын орчны хөрс болон барилга байгууламжид

доорх зоорины давхарт хадгалж байснаас тус газрын орчны хөрс болон барилга байгууламжид ихээр шингэсэн, лабораторийн барилга дотор болон ойр орчимд химийн бодисын хурц эхүүн үнэр ихээр тархсан байдалтай байгаа нь Булган аймгийн МЭЛ-ийн ажилтан нарын хөдөлмөрлөх, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах эрх ноцтой зөрчигдөж байна хэмээн Монгол улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос хийсэн хяналт шалгалтаар илрүүлжээ. Хөвсгөл аймгийн МЭЛ-ийн барилгын гадна даацын тоосгон хана ус, чийгийн нөлөөгөөр илжирч муудан, зарим хэсэгт бутран унадаг, гадна хананд хагарлууд үүссэн, бетон суурь, бетон хаяавчинд хагарал гэмтэл ихтэй гэж Мэргэжлийн хяналтын Барилгын техникийн улсын байцаагч дүгнэжээ.

Энэхүү стратеги төлөвлөгөөг боловсруулах явцад аймгуудын МЭЛ-удад хийсэн тоног төхөөрөмжийн судалгааг 2-р хавсралтаар харууллаа. Аймгуудын МЭЛ-удад одоо байгаа зарим тоног төхөөрөмжийг засах, ялангуяа нян, ийлдэс, молекул биологийн лабораторийн зарим тоног төхөөрөмжийг шинэчлэх шаардлагатай байна.

1.2. МЭЛ-удын боловсон хүчин

Мал эмнэлгийн сүлжээ лабораториудын хүний нөөцийн талаар Стратегийн төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн судалгааны дүнгээс үзэхэд:

1. АМЭЛ-т ХААИС, Мал эмнэлгийн сургуулийг 1995-2020 онд төгссөн малын эмч нар ажиллаж байна. Нийт эмч, лаборант нарын 91.6% нь 2000 оноос хойш, 58.6% нь 2011-2020 онд буюу сүүлийн 10 жилд, 38% нь 2016-2020 он буюу сүүлийн 5 жилд төгссөн төгсөгчид байна (График 1). Ийнхүү лабораторийн шинжээч эмч нарын дийлэнх хувийг шинэ төгссөн залуу эмч нар эзэлж байгаа нь тэдгээрийг сургах, мэргэшүүлэх, дадлагажуулах зайлшгүй шаардлага тулгарч буйг харуулж байна;
2. Лабораторид ажиллаад 1 жил хүрээгүй байгаа эмч, лаборант 4 (5%), 1-5 жил ажиллаж байгаа 36 (43%) эмч, 5-10 жил ажиллаж байгаа 28 (34%) эмч, 10-15 жил ажиллаж байгаа 10 (12%) эмч, 15-20 жил ажиллаж байгаа 4 (5%) эмч, 20-оос дээш жил ажиллаж байгаа 1 (1%) эмч байна. Эндээс үзэхэд нийт эмч, ажилтны 50 хувь нь 5 хүртэл жил ажиллаж байгаа шинэ төгссөн залуучууд байгаа бөгөөд 10-аас дээш жил ажилласан ажлын дадал, туршлага суусан, тодорхой хэмжээнд мэргэшсэн эмч дөнгөж 18 хувийг эзэлж байгаа нь АМЭЛ-ийн хүний нөөцийг чадавхжуулах шаардлага зүй ёсоор тавигдаж буйг батлан харуулж байна;




График 1. МЭЛ-ийн шинжээч нарын ажилласан хугацаа

3. АМЭЛ-д ажиллаж буй эмч нарыг лабораторийн албан тушаалд ажилласан байдал, хугацаагаар нь судалж үзэхэд лабораторийн нян, ийлдэс, шимэгч, ариун цэврийн шинжээч, лаборантын ажилд сүүлийн 5 жилд шинэ төгсөгч эмч олноор томилогдон ажиллаж байгаа боловч дээрх ажлын байруудад тогтвортой ажиллаагүй, нэг ажлын байранд олон удаа сэлгэж, орж гарч, өөрчлөгдөж, маш тогтворгүй ажилласан нь харагдаж байна (График 2).



График 2. МЭЛ-т ажиллах хугацаандаа албан тушаалаа өөрчилсөн байдал

АМЭЛ-ийн эмч нарын сүүлийн 5 жилийн сургалтад хамрагдсан байдлыг судалж үзэхэд (График 3) 2016-2021 онд нийт 40 гаруй удаагийн сургалтад хамрагдсан боловч АМЭЛ-ийн эмч нарыг тухайн эрхэлж буй ажил үүргийн чиглэлээр нийтлэг хамруулсан чадавхжуулах сургалт хийгдээгүй, өөрөөр хэлбэл 2017 оноос хойш УМЭАЦТЛ-ос зохион байгуулсан зорилтот өргөн хүрээний төлөвлөгөөт сургалтууд хийгдээгүй байна. Нийт сургалтын 85 хувь нь 1-5 эмчийн хүрээнд хийгдсэн, АМЭЛ-уд өөрсдийн хүсэлт, санаачилгаар дадлагажих, дагалдан сурах хэлбэрээр хамрагдсан нь ажиглагдаж байна. Иймд сүлжээ лабораториудын эмч нарыг чадавхжуулах сургалтын бодлого төлөвлөгөө зайлшгүй хэрэгтэй байна.



График 3. МЭЛ-ийн шинжээч нар сургалтад хамрагдсан байдал

Ийнхүү үндэсний хэмжээнд МЭЛ-ын хамтын ажиллагааг уялдуулан нэгдсэн удирдлагаар хангаж, дэд бүтэц, хүний нөөц шинжээчийн ур чадвар, оношилгоо, санхүүгийн чадавхыг сайжруулан мал эмнэлгийн лабораториудыг жигд хөгжүүлж, 60%-с дээш буюу дундаас дээд түвшинд хүргэхийн тулд үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн дагуу МЭЛ-ийн үндэсний сүлжээг хөгжүүлэх стратеги төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлэх нийгмийн шаардлага тулгарсан юм.

ХОЁР. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Мал эмнэлгийн хоёрдугаар шатлалын лабораторийг хөгжүүлэх дунд болон урт хугацааны стратегийг боловсруулах ажлын хүрээнд аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагаанд үнэлгээ хийж өнөөгийн байдлыг тогтоосон. Мөн энэхүү стратеги төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн хүрэх түвшнийг тогтоолоо.

Мал эмнэлгийн лабораторийн сүлжээний бүрэлдэхүүнд багтаж байгаа лаборатори нь үйл ажиллагааны хамрах хүрээнээс хамаарч дөрвөн шатлалтай байна. Нэгдүгээр шатлалд сум, дүүргийн түвшинд үйл ажиллагаа явуулж байгаа мал эмнэлгийн анхан шатны лаборатори, мах боловсруулах үйлдвэр, худалдааны төв, хүнсний зах, дэлгүүр, бусад байгууллагын дэргэдэх харьяа лабораторийг, хоёрдугаар шатлалд аймаг, нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн лаборатори, оношилгоо, шинжилгээний төрөлжсөн лабораторийг, гуравдугаар шатлалд бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн лабораторийг, дөрөвдүгээр шатлалд улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа нэгдсэн лаборатори, аль нэг чиглэлээр төрөлжсөн лавлагаа лабораторийг тус тус хамруулна.

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Мал эмнэлгийн лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлэх

ДӨРӨВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Шуурхай, найдвартай байдал, чанарын болон удирдлагын тогтолцоог нэвтрүүлэх замаар мал эмнэлгийн сүлжээ лабораторийн жишиг үйлчилгээ бий болгоход оршино.

ТАВ. СТРАТЕГИЙН ЗОРИЛТ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ҮР ДҮН

5.1. Мал эмнэлгийн лабораторийн иж бүрэн дэд бүтцийг түвшин бүрд хөгжүүлэх;

5.2. Мал эмнэлгийн лабораторийн үйл ажиллагааг жигд, тодорхой болгох зорилгоор шаардлагатай технологи дамжуулалт, сургалтын системийг боловсруулж, хөгжүүлэх;

5.3. Хүнсний аюулгүй байдал, нийтийн эрүүл мэндийг хамгаалах мал эмнэлгийн оношилгооны үйл ажиллагааг жигдрүүлж, мал, амьтны өвчнийг оношлоход мөрдөх нэгдсэн САЗ-ууд боловсруулан, албажуулж, мөрдүүлэх;

5.4. Удирдлага, санхүүжилтийн дэвшилтэт шийдлийг нэвтрүүлж, бие даасан лабораторийн сүлжээг бий болгох;

5.5. Мал эмнэлгийн лабораторийн сүлжээ (МЭЛС)-ний мэдээллийн урсгалыг сайжруулж, өвчинтэй тэмцэх, сэргийлэхэд үр дүнтэй ашиглах боломжийг бүрдүүлэх

ЗУРГАА. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ:

Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах тогтолцоо нь улсын хэмжээнд Мал амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, мал амьтны эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, лаборатори, эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн байгууллага, аймаг нийслэлд мал эмнэлгийн байгууллага, лаборатори, сум дүүрэгт мал эмнэлгийн тасаг, лаборатори болон мал эмнэлгийн үйлчилгээний нэгжээс бүрдэнэ гэж Мал эмнэлгийн байгууллагын нэгдмэл бие даасан бүтэц тогтолцоог хуульчлан баталсан.

Мөн хуулийн 29 дүгээр зүйлд улс, аймаг нийслэл, сум дүүргийн мал эмнэлгийн лабораторийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагаа, чиг үүргийг, 29 дүгээр зүйлийн 29.4-д сүлжээ лабораторийн ажиллах журам, үндэсний лавлагаа лабораторийг сонгох журмыг Мал амьтны эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн батална гэж заасан нь улс, аймаг, сумын түвшинд мал эмнэлгийн лаборатори сүлжээ байдлаар ажиллах хууль эрх зүйн үндэс болно.

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		
Үүнээс	Тухайн салбарын хуулийн тоо	1
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	16
<p>Ерөнхий чиг үүрэг-1: Мал амьтны эрүүл мэндийг хамгаалах Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчин гарах, тархах шалтгаан нөхцөлийг хязгаарлан эрүүлжүүлэх арга хэмжээг цогцоор нь хэрэгжүүлж, халдварт өвчингүй тайван байдлаа дотооддоо болон гадаад оронд баталгаажуулан хадгалж, хүн амыг эрүүл, аюулгүй хүнсээр, боловсруулах үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангаж, мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортлох боломжийг нэмэгдүүлнэ.</p>		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Халдварт өвчний оношилгоо тандалт	Оношлох шинжилгээ	УМЭАЦТЛ, НМЭЛ, АМЭЛ,
	Тандах шинжилгээ	
	Баталгаажуулах шинжилгээ	
ҮЧҮ-2: Шимэгчтэх өвчний оношилгоо, урьдчилан сэргийлэлт	Оношлох шинжилгээ	УМЭАЦТЛ, НМЭЛ, АМЭЛ, СДМЭЛ
	Тандах шинжилгээ	
ҮЧҮ-3: МАА-н гаралтай түүхий эд бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналт	Ариун цэврийн шинжилгээ	УМЭАЦТЛ, НМЭЛ, АМЭЛ, СДМЭЛ
	Антибиотик, эмийн үлдэгдэл тодорхойлох шинжилгээ	УМЭАЦТЛ, НМЭЛ, АМЭЛ, СДМЭЛ
Ерөнхий чиг үүрэг-2: Лабораторийн мэдээллийн нэгдсэн санг хөгжүүлэх.		
Ерөнхий чиг үүрэг-3: Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журам болон салбарын бусад хууль тогтоомж, дүрэм журам, заавар, стандартыг хэрэгжүүлэх		

ДОЛОО. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ, ОЙЛГОЛТ

7.1. Мал эмнэлгийн лабораторийн сүлжээний одоогийн байдал

➤ Мал эмнэлгийн лабораторийн сүлжээний бүтэц

Улсын түвшин (Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори (УМЭАЦТЛ))

Аймгийн түвшин (21 аймгийн мал эмнэлгийн лаборатори (АМЭЛ), Нийслэлийн мал эмнэлгийн лаборатори (НМЭЛ))

Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори (МЭЭСБУЛ)

➤ Мал эмнэлгийн лабораторийн хүний нөөц, хууль эрх зүйн үндэс

No	Түвшин	Лабораториуд	Орон тоо	Ажилтан орон тооны хууль эрх зүйн үндэс
1	Улс	УМЭАЦТЛ	52	- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль - ЗГХА МЭЕГ-ын даргын тушаал А-45 (2019-04-08)
2		МЭЭСБУЛ	33	- ЗГХА МЭЕГ-ын даргын тушаал А-64 (2020- 03-09)
3	Аймаг	АМЭЛ	5	- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль - ХХААХҮ-ийн сайдын тушаал А-13 (2021-02-02)
		НМЭЛ	11	- Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль - ХХААХҮ-ийн сайдын тушаал А-13 (2021-02-02)

7.2. Давуу ба сул талууд, боломж ба эрсдэлийн шинжилгээ (ДСБЭ/SWOT шинжилгээ)

Давуу тал:

- МЭЛ-дийн Үндсэн ЛҮА-н Газарзүйн байршил, Үндсэн хангамж, байгууллага төрлүүд ерөнхийдөө давуу (64.6-100%);
- МЭЛ-удын бүхий л шатанд ЛММС бий болж (дээж бүртгэлийг маш сайн хөтөлж, ЛММС хэрэглэдэг), идэвхтэй хэрэглэж байна;
- Урвалж бодисын хангамж, чанарын баталгаажуулалт, харилцаа холбооны хэрэгсэл, лабораторийн үндэсний сүлжээ дунд зэргийн

Сул тал:

- Бүтэц, орон тоо МЭЛ-ийн үйл ажиллагаанд нийцдэггүй;
- Бүс, аймгийн түвшний МЭЛ-ууд төсөв байхгүй, бүх түвшний МЭЛ-д судалгаа явуулах, байгууламжаа сайжруулах төсөв байхгүй;
- Цалин хангамж, урамшууллын тогтолцоо муу;
- Нэг ажилтан нөгөөгөө орлож ажиллах чадвар сул;
- Био-аюулгүйн 3-р түвшний био-хамгааллын төхөөрөмж, вируст, паразиттах, халдваргүй өвчин оношилгоо, задлан, гисто-эмгэг судлалын тоног төхөөрөмж хомс;
- Лабораторийн тоног төхөөрөмж янз бүрийн загварынх байдгаас засвар, үйлчилгээ хийхэд хүндрэлтэй;
- ПГУ-ын тоног төхөөрөмжийг тогтмол хэрэглэдэггүй (АМЭЛ-дад огт хэрэглэдэггүй);
- Шинэ ажилтны сургалт хангалтгүй;
- Сургалт - бүх АМЭЛ-н байнгын сул тал (ЛЗД, лабораторийн ур чадвар, БАБ, ЧБ/ЧХ, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, тохиргоо);
- Иүүхү лаборатори чанарын системийн

	<ul style="list-style-type: none"> - МЭЛ-д шинжлэх дээжийн тоо цөөн; - Лабораторийн өрөөнүүд цонхтой, агааржуулагч (эйр кондишнинг -АС)-гүй; - Лабораторийн био-аюулгүйн түвшин тодорхойгүй; - БАБ/БХ-ын САЗ боловсруулаагүй, хэрэглэдэггүй, УМЭАЦТЛ-с бусад МЭЛ-ийн Био-аюулгүйн кабинетуудыг шалгаагүй, ажлын цагаар бүх АМЭЛ руу хэн нэгэн амархан нэвтрэх, мөн лабораториудаас халдвар гадагш алдагдах боломжтой (санаатай болон санамсаргүй байдлаар); - Химийн бодис, аюултай хог хаягдал устгах журам, тогтолцоо байхгүй; - Тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ хийх мэргэжилтэн байхгүй
<p>Боломжууд:</p> <ul style="list-style-type: none"> - Орон нутгийн засаг захиргааны хуваарилалтыг сайн тодорхойлсон; - МЭЛ-ийн тогтвортой оршин тогтнох байдал, бие даасан гүйцэтгэлийг хангах мал эмнэлгийн үйлчилгээний босоо бүтэц; - Хангалттай бус ч, зөвхөн лабораторид ажиллахаар томилогдсон ажилтны орон тоо; - Өнөөгийн нөхцөл байдлыг сайжруулах МЭЭГ-ын удирдлагын сайн дэмжлэг; - Техник туслалцааны олон эх үүсвэртэй 	<p>Аюул:</p> <ul style="list-style-type: none"> - Улс төрийн нөлөөлөл; - Тандалт судалгааны хөтөлбөр, чиглэсэн шинжилгээнүүдэд улсын санхүүжилт буурах буюу багасах; - МЭЛ-ийн дэд бүтцийг сайжруулах ажиллагааны улсын санхүүжилт байхгүй; - МЭЛ-ийн бэлэн байдал хангагдаагүй нөхцөлд шинэ өвчин дэгдэх; - Шинжлэх арга, аргачлал нь тодорхойгүй буюу баталгаажаагүй шинэ өвчин дэгдэх; - Шинэ болон гоц халдварт өвчин дэгдвэл МЭЛ хоорондын шуурхай хамтын ажиллагаа дутмаг

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН: (ТӨЛӨВЛӨЛТИЙН МАТРИЦ)

8.1. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн, ерөнхий нөхцөл, бүтэц зохион байгуулалт:

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн лабораторийн ерөнхий нөхцөл</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн байршил</i>					
Зорилт-1. Барилга, байгууламжийн үндсэн дэд бүтцийг сайжруулах	МЭЛ-дад үнэлгээ хийж, дүгнэлт гаргах	Лабораториудын үнэлгээ, дүгнэлт	2016 онд бүх МЭЛ, 2020-2021 онд 11 МЭЛ үнэлгээнд тус тус хамрагдсан	Аймаг, нийслэл, улсын МЭЛ-уд үнэлгээнд бүрэн хамрагдаж дүгнэлт бий болсон байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оновчтой бүтцийг буй болгох	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оновчтой бүтэц	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оновчтой бүтэц хараахан бий болоогүй	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оновчтой бүтэц бий болсон байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Стандартын шаардлага хангасан нэг загварын барилга, байгууламжийн зураг төсөл, ТЭЗҮ-ийг боловсруулж, зураг төслийн дагуу барих аж ахуй нэгжийг сонгон шалгаруулах	Стандартын шаардлага хангасан, нэг загварын барилгын ТЭЗҮ, аж ахуй нэгжийн сонгон шалгаруулалт	Стандартын шаардлага хангасан, нэг загварын барилгын нэгдсэн зураг төсөл байхгүй, ТЭЗҮ гараагүй, төсөв төлөвлөгдөөгүй	2022 онд багтаан лабораторийн байрны зураг төсөл, ТЭЗҮ-г бэлэн болгох, сонгон шалгаруулалт зарлаж, гүйцэтгэх аж ахуй нэгжтэй гэрээ байгуулсан байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Нэг загварын, стандартын шаардлага хангасан лабораторийн барилгыг зураг, төслийн дагуу барьж, ашиглалтад оруулах	Лабораторийн байртай болсон байна.	Барилга байгууламж нь нэг загварын бус, харилцан адилгүй, лабораторийн стандарт, шаардлага хангаагүй	2022-2027 онд 9 аймгийн МЭЛ-ийн барилгыг барьж ашиглалтад оруулсан байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр

	Лабораторийн байгууламжийг төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох	Лабораторийн барилгыг төвлөрсөн халаалт, цэвэр, бохир усны төвийн шугамд холбосон байна.	Сүхбаатар, Өвөрхангай, Сэлэнгэ, Хэнтий аймгийн лаборатори халаалт, цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбогдоогүй	2021-2024 онд багтаан халаалт, цэвэр, бохир усны төвлөрсөн шугамд холбох, шинэчилсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Лабораторийн барилга байгууламжийг төвийн эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй холбох, болзошгүй нөхцөлд зөөврийн цахилгааны эх үүсвэр бүхий төхөөрөмж, тог баригчаар хангах	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрт холбогдсон, нөөц генератор, цахилгааны гүйдэл тогтворжуулагч, тог баригч төхөөрөмж	Төвийн эрчим хүчний эх үүсвэртэй холбогдсон ч нөөц генератор, цахилгааны гүйдэл тогтворжуулагч, тог баригч төхөөрөмжөөр хангагдаагүй	2021-2024 онд багтаан 10 аймгийн лабораторийг нөөц генератор, цахилгааны гүйдэл тохируулагч, тог баригчаар хангасан байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
Зорилт-2. Зохион байгуулалт, бүтэц, орон тоог тодорхойлох	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн бүтэц, орон тоо, үйл ажиллагааг тодорхойлж, албажуулах	Үндэсний хэмжээнд Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оновчтой бүтэц, орон тоо	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн түвшинд бүтэц, орон тоо шаардлагад нийцээгүй, оновчтой бус, үйл ажиллагаа явуулахад бэрхшээл учирч байна. ажил үүргийн хуваарь тодорхойгүйгээс дийлэнх шинжээчид малын эмчийн үүрэг гүйцэтгэж, малын эрүүл мэндийн тусламж үзүүлэх үйлчилгээнд явдаг	Улс, бүс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд лабораторийн үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлж, оновчтой бүтэц, орон тоог баталгаажуулж, ижил түвшинд хүргэх, 2022 оноос хэрэгжилтийг хангасан байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Лабораторийн шинжээчийн албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж, албажуулах	Лабораторийн шинжээчийн албан тушаалын тодорхойлолт	Лабораторийн шинжээчийн албан тушаалын тодорхойлолт байхгүйгээс дийлэнх шинжээчид үндсэн ажлын хажуугаар малын эмчийн үүрэг гүйцэтгэж, малын эрүүл мэндийн тусламж үзүүлэх үйлчилгээнд явдаг	Лабораторийн шинжээч нар батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу ажиллана	Улсын төсөв
Зорилт-3. Тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүнд үнэлгээ хийх, нэгэн	МЭЛ-дад ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүнд үнэлгээ хийж, хангамж, нөхцөл байдлыг тодорхойлох	Үнэлгээ хийгдсэн байна.	Үнэлгээ хийгдэж байгаагүй	2021-2022 онд багтааж МЭЛ-дад ашиглаж байгаа тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүнд үнэлгээ хийгдсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Үнэлгээнд үндэслэн шинэчлэл	Шинэчлэл хийх багаж,	Лабораторийн хэмжээнд	2021-2022 онд багтаан	Улсын

жигд тоног төхөөрөмжийг тогтмол нийлүүлэх, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний төв байгуулах	хийх багаж тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг МЭЛ тус бүрд тодорхойлох	тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүний нэр, төрөл, тоо хэмжээг сүлжээ лабораторийн хэмжээнд тодорхойлсон байна.	тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүнийг шинэчлэх талаар нэгдсэн төсөөлөл байхгүй.	лабораториудад шинэчлэл хийх багаж, төхөөрөмж, багаж, хэрэгсэл, эм урвалж, хэрэглэгдэхүүний тоо, хэмжээ, нэр төрлийн жагсаалтыг аймаг тус бүрээр гаргасан байна.	төсөв, төсөл, хөтөлбөр
	Шинэчлэх багаж, төхөөрөмжийг худалдан авах, хүргэх, хүлээлгэн өгөх суурилуулах	Багаж, тоног төхөөрөмжийг худалдаж авах	Лабораториудад ашиглаж байгаа ихэнх тоног төхөөрөмжүүд хуучирсан, ашиглах боломжгүй болсон.	2021-2027 онд багтаан лабораториудын багаж, тоног төхөөрөмжид шинэчлэл хийсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	Төвийн болон орон нутгийн лабораторид байгаа багаж, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ, найдвартай ажиллагааг хариуцах мэргэжлийн инженерийн багтай болох	Засвар, үйлчилгээний нэгж эсвэл инженерийн баг	Засвар үйлчилгээ хийх инженер, техникийн ажилтан/ баг байхгүй.	Үндэсний хэмжээний инженерийн багтай болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр

8.2. Лабораторийн тогтвортой сургалт, мэдлэг дамжуулалт:

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Лабораторийн тогтвортой сургалт, мэдлэг дамжуулах ажлыг бий болгох</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Лабораторийн тогтвортой сургалт, мэдлэг дамжуулалтыг тогтмол болгох</i>					
	Мал, амьтдын өвчнийг оношлох, тандалт судалгаа явуулах, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр тогтвортой, үргэлжилсэн сургалтын модулийг боловсруулах	МЭЛ-ийн оношилгоо, шинжилгээ, тандалт судалгааны чиглэлээр сургалтын оновчтой модуль	МЭЛ-ийн оношилгоо, шинжилгээ, тандалт судалгааны чиглэлээр сургалтын модуль байхгүй	Мал, амьтдын өвчнийг оношлох, тандалт судалгаа явуулах, хүнсний аюулгүй байдлын чиглэлийн үргэлжилсэн сургалтын модультай болсон байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт

Зорилт -1. Мал, амьтдын өвчнийг оношлох, тандалт судалгаа явуулах, хүнсний аюулгүй байдлын чиглэлээр тогтвортой, үргэлжилсэн сургалтын модулийг боловсруулах	Сургалтын сонголтуудыг бий болгож, ажлын байран дахь болон бусад сургалт зохион байгуулах	Тодорхой сонголттой сургалтууд	Сургалтыг тодорхой сонголттойгоор зохион байгуулдаггүй	Хэрэгцээнийх нь сонголтгоор сургалт зохион байгуулдаг болсон байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	МЭЛ-ийн сургалтад кредит тогтолцоог хөгжүүлж, түүнийг ажилтан нарын ажлын хуваарилалт, тушаал дэвшилттэй уялдуулах	МЭЛ-ийн сургалтад кредит тогтолцоо	МЭЛ-ийн сургалт хомс, түүнчлэн кредит тогтолцоо хөгжөөгүй	МЭЛ-ийн сургалт хомс, түүнчлэн кредит тогтолцоо хөгжөөгүй	Лабораторийн сургалтад кредит тогтолцоо бий болж, ажилтан нарын ажил үүргийн хуваарилалттай уялдаг болсон байна
	МЭЛ-ийн шинжээч нарыг гадаад, дотоодын, ажлын байранд нь мэргэшүүлэх, дадлагажуулах, чадавхжуулах сургалтад хамруулах, сургагч нарыг бэлтгэх	МЭЛ-ийн шинжээч нарын ажил үүргийн чиглэлийн сургалт	МЭЛ-ийн шинжээч нарт зориулсан мэргэшүүлэх, дадал олгох сургалт сүүлийн 3 жилд хийгдээгүй, шинээр ажилд орж байгаа шинжээч нар сургалтад хамрагдаагүй байна.	МЭЛ-ийн сургалтын төлөвлөгөө боловсруулан, үе шаттайгаар хэрэгжүүлж, шинжээч нарыг мэргэшүүлсэн байна. Лабораторийн үйл ажиллагааны тухайн чиглэлээр сургагч нарыг бэлтгэсэн байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Лабораторийн эрхлэгч болон лабораторийн ажилтан нарыг хамруулсан улсын, бүсийн хурал, зөвлөгөөн, семинар, вебинар зохион байгуулах	Лабораторийн ажилтан нарын улсын зөвлөгөөн, аймаг, бүсийн семинар, вебинар	УМЭАЦТЛ-ос жил бүр зохион байгуулдаг "Оношлох эрдэм- дэвшилтэт арга" ОУБХ, МоМЭХ-оос бүсчлэн зохион байгуулдаг "Бүсийн МЭ-ийн чухал асуудлууд" ОУБХ-д лабораторийн зарим эмч нар хамрагддаг байсан. 2018 оноос хойш бүсийн хурал зохион байгуулагдаагүй, лабораторийн эмч ажилтнуудын нэгдсэн болон бүсийн хурал зөвлөгөөн семинарыг зохион байгуулдаггүй.	МЭЛ-ийн улсын зөвлөгөөн, семинар, вебинар, туршлага солилцох уулзалт, үзүүлэх сургуулийг тогтмол (Улсын зөвлөгөөнийг жилд 1 удаа, лабораторийн ажилтан нарын улсын зөвлөгөөнийг 2 жилд 1 удаа, аймаг, бүсийн семинар, вебинарыг хагас жил тутам 1 удаа) зохион байгуулдаг болсон байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр

Зорилт-2. МЭЛ-ийн шинжээч нарын мэргэшил, дадал, ур чадварыг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.	MNS ISO/IEC 17025 стандартын сургалтад лабораторийн удирдлага, шинжээч нарыг хамруулах	Лабораторийн чанарын менежер, шинжээч нар сургалтад хамрагдсан сертификат	2020 онд MNS ISO/IEC 17025 стандартын сургалт, дотоод аудитын нэгдсэн сургалт, зохион байгуулсан.	МЭЛ-ийн 50-с цөөнгүй удирдах албан тушаалтан, шинжээч нар MNS ISO/IEC 17025 стандартын сургалтад хамрагдаж, сертификат авсан байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Лабораторид тулгамдсан асуудлаар ажлын байрны зөвлөх үйлчилгээ үзүүлэх	Зөвлөх үйлчилгээ	Лабораторийн үйл ажиллагааны чиглэлээр зөвлөх үйлчилгээ байхгүй	Тухайн лабораторийн хүсэлтээр ажлын байранд зөвлөх үйлчилгээ үзүүлэх багийг томилон ажиллуулдаг, туршлага солилцох уулзалт, үзүүлэх сургуулийг төлөвлөгөөтэйгөөр зохион байгуулдаг болсон байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт

8.3. Лабораторийн итгэмжлэлийн тогтолцоо, биоаюулгүй байдал:

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: MNS ISO/IEC 17025: стандартын шаардлага хангасан сүлжээ лабораторийг бий болгох</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: MNS ISO/IEC 17025: стандартаар итгэмжлэгдэх, лабораторийн итгэмжлэлийг тогтвортой байлгах</i>					
Зорилт-1. MNS ISO 17025: стандартаар итгэмжлэлд хамрагдах, лабораторийн итгэмжлэлийг тогтвортой байлгах	MNS ISO 17025: стандартын итгэмжлэлд хамрагдахад зөвлөн туслах баг байгуулах буюу энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай гэрээ байгуулж хамтран ажиллах	Зөвлөн туслах баг байгуулсан байна. Хамтын гэрээ байгуулсан байх	Зөвлөн туслах баг байхгүй	MNS ISO 17025: стандартын итгэмжлэлд хамрагдахад дэмжлэг үзүүлдэг болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт
	Итгэмжлэлд хамрагдахад шаардлагатай санхүүжилтийг улсын төсөвт жил бүр тусгаж өгөх	Итгэмжлэлд орох санхүүжилтийг тухай бүр хуваарилан олгосон байх	Зөвхөн 2020 онд МЭЭГ-с 17 аймагт тус бүр 10.0 сая төгрөг олгосон.	МЭЛ-уд итгэмжлэлд хамрагдсан байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт

Зорилт-2. Лабораторийн түвшин тус бүрд үйл ажиллагааны шаардлагыг тогтоох	Итгэмжлэлийн хүрээг тодорхойлох	Тухайн лабораторийн чадавхад тохирсон байх	Чадамж, үйл ажиллагаандаа тохирсон итгэмжлэлд хамрагдаагүй 7 МЭЛ байна.	Лабораториуд Олон улсын болон үндэсний хэмжээнд тохирсон чадавхтай болох	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт
Зорилт-3. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн нэгдсэн баримт бичгийг боловсруулан мөрдөх	Чанарын гарын авлагыг сайжруулан боловсруулах, өөрчлөлт оруулах	MNS ISO/IEC 17025-ийн шаардлага хангасан байх	Итгэмжлэл 2-4 жилийн хугацаатай байгаа бөгөөд 15 аймаг, нийслэлийн МЭЛ итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдсан, 7 аймгийн МЭЛ итгэмжлэлд ороогүй байна.	2021-2023 онд бүх аймгийн МЭЛ итгэмжлэлд хамрагдсан буюу хамрагдахаар хүсэлтээ өгсөн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт
	Чанарын хяналтын журмуудыг боловсруулах	Баталгаажсан, чанарын хяналтын журмууд	Чанарын хяналтын ерөнхий жишиг журмуудыг 2020 онд боловсруулсан.	Тухайн МЭЛ-ийн чадавх, итгэмжлэлийн хүрээний шаардлагад нийцсэн журмуудтай болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Стандарт ажлын заавар (CA3) батлуулах	Эрх бүхий байгууллагаар баталгаажсан CA3	Ижил үйл ажиллагааны нэгдсэн CA3-ууд байхгүй	Эрх бүхий байгууллагаар баталгаажсан, ижил үйл ажиллагааны нэгдсэн CA3-тай болно.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
Зорилт-4. Лабораторийн ур чадварын үнэлгээ, лаборатори хоорондын харьцуулалтыг тогтмолжуулах	MNS ISO/IEC 17043 болон олон улсын итгэмжлэлтэй лабораторийн ур чадварын үнэлгээнд хамрагдах, лаборатори хоорондын харьцуулалтад орох	Ур чадварын үнэлгээ, лаборатори хоорондын харьцуулалтыг тогтмол болгох	MNS ISO/IEC 17025 стандартын шаардлагыг бүрэн мөрддөггүй	Сүлжээ лабораторийн журмын дагуу төлөвлөгөө гаргаж, ур чадварын үнэлгээ, лаборатори хоорондын харьцуулалтад хамрагддаг болно.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Лабораторийн хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, тохиргоо хийх	Лабораторийн хэмжих хэрэгслийг гэрчилгээжүүлэх, тохиргоо хийх	Итгэмжлэгдсэн лабораториос бусад лабораторид тогтмол хийдэггүй	Бүх хэмжих хэрэгсэл баталгаажсан гэрчилгээтэй болно, тохиргоо хийх CA3-тай байна, CA3-ын дагуу тохиргооны бүртгэлтэй байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ хийх	Дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ хийх	Дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ нь MNS ISO/IEC 17025-ын шаардлагад зарим МЭЛ	МЭЛ-уд дотоод аудит болон удирдлагын дүн шинжилгээ хийж, залруулах, сэргийлэх, сайжруулах ажил хийгдсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт

			нийцэхгүй байна.		
Зорилт-5. Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хараат бус байдлыг бий болгох	Улс төрийн нөлөөллөөс ангид байж, шатлал бүрийн лабораторийн удирдлага, мэргэшсэн ажилтан нарын ажлын байрны тогтвортой байдлыг хангах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Эрх зүйн орчин бий болно	Удирдлага, мэргэшсэн ажилтан нарын ажлын байрны тогтвортой байдлыг хадгалах эрх зүйн орчин байхгүй.	Лабораторийн удирдлага, мэргэшсэн ажилтан нарын албан тушаал, ажлын байр хууль, эрх зүйгээр хамгаалагдсан байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
Зорилт-6. Лаборатори нь өөрийн нөөц бололцоог бий болгох чадамжийг бүрдүүлэх	Лаборатори нь өөрийн үйл ажиллагаанаас олсон орлогоо захиран зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх	Орлогоо зарцуулах эрхзүйн орчин бүрдсэн байна.	Эрх зүйн орчин бүрдээгүй.	Орлогоо зарцуулах эрхзүйн орчин бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Улсын болон орон нутгийн төсвөөр гүйцэтгэх үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ модулийг боловсруулах,	Улсын болон орон нутгийн төсвөөр гүйцэтгэх үйл ажиллагааны санхүүжилтийн шинэ модуль бий болсон байна	Зөвхөн зарим өвчний тандалт судалгааг Улсын болон орон нутгийн төсвөөр хийж байгаа	Санхүүжилтийн шинэ модультай болсон байна.	Улсын төсөв, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Хувийн хэвшилд үзүүлэх үйлчилгээний санал, Төр ба хувийн хэвшлийн түншлэлийг лабораторийн үйлчилгээнд нэвтрүүлэх	Гэрээ байгуулан хамтарч ажиллана	Хувийн хэвшил болон МЭЛ-ийн хамтын ажиллагаа сул	Хувийн хэвшил болон МЭЛ-ийн хамтын ажиллагаа сайжирч, харилцан үйлчилгээ, итгэлцэл бий болно. Эрүүл хүнсээр хангах баталгаа бий болсон байна.	Улсын төсөв, Хувийн хэвшлийн санхүүжилт
Зорилт-7. Лабораторийн хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлэх	Лабораторийн шинжээч нарт зориулсан шаталсан сургалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэн өндөр ур чадвартай, мэргэшсэн шинжээч бэлтгэх	Ур чадвартай, мэргэшсэн шинжээч нар бэлтгэгдсэн байна.	2019 оноос хойш лабораторийн чиглэлээр сургалт зохион байгуулагдаагүй	Шинжээч эмч нарын ур чадвар, мэргэшсэн байдал дээшилсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Лабораторийн боловсон хүчнийг гадаад, дотоодын сургалтад хамруулж, сургаж дадлагажуулах	Нарийн мэргэшсэн шинжээчдийг бэлтгэх	Залуу шинжээч нар өвчний оношилгоо, лабораторийн шинжилгээ хийх ур чадвар, шинжилгээний хариуг бие даан шийдвэрлэх туршлага	Залуу шинжлэгч нарыг тогтвортой ажиллуулах, нарийн мэргэшлийн сургалтад тогтмол хамрагдах нөхцөлд бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, хувийн хэвшлийн санхүүжилт

			багатай.		
	Лабораторийн боловсон хүчний нөөцийг бий болгох	Боловсон хүчний нөөц бүрдсэн байна.	Лабораторийн боловсон хүчнийг шинээр бэлтгэх, ажлын байрны сургалт, дадлагыг зохион байгуулдаггүй.	Лабораторийн боловсон хүчнийг шинээр бэлтгэх буюу ажлын байрны сургалт, дадлагыг зохион байгуулдаг болсон байна.	Түншлэгч байгууллагуудтай хамтрах
	МЭЛ-ийн хөдөлмөрийн нөхцөлийг тогтоолгох, ажилтан нарт хэвийн бус нөхцөлийн тэтгэмж олгох хууль эрх зүйн орчныг бий болгох	МЭЛ-ийн хөдөлмөрийн нөхцөл тогтоож, ажилтан нар хэвийн бус нөхцөлийн тэтгэмж авах эрх зүйн орчин бүрдсэн байх.	МЭЛ-ийн хөдөлмөрийн нөхцөл тогтоогдоогүй, ажилтан нарт хэвийн бус нөхцөлийн тэтгэмж авч чадахгүй байна.	МЭЛ-ийн хөдөлмөрийн нөхцөл тогтоогдсон байна, Ажилтан нарт хэвийн бус нөхцөлийн тэтгэмж олгогдсон байна.	Улсын төсөв
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Лабораторийн Био-аюулгүй ажиллагаа, био-хамгаалал</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Лабораторийн био-аюулгүй байдал, хамгаалалт</i>					
Зорилт-1. Лабораторийн биоаюулгүй байдлыг хангах	Лабораторийн барилгыг 24 цагийн хамгаалалтын системтэй, автоматаар түгжигддэг хаалгатай болгон тусгай код эзэмшдэг эрх бүхий ажилтнаас өөр этгээд нэвтрэх боломжийг хязгаарлах	Лабораторийн аюулгүй байдлыг сахиулахын тулд 24 цагийн хамгаалалтын системтэй, хаалга нь тусгай кодтой байх шаардлагатай.	АМЭЛ-удад 24 цагийн хамгаалалтын систем байхгүй, гаднын этгээд нэвтрэхийг бүрэн хязгаарлах боломжгүй байна.	АМЭЛ-уд автоматаар түгжигддэг хаалгатай, ажилтан нар тусгай картаар нэвтрэдэг болно, АМЭЛ бүрд хяналтын камер суурилуулж, үйл ажиллагааг хянах боломж бүрдсэн байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Лабораторийн сүлжээний хүрээнд дулаан мэдрэгч систем, шүүлтүүртэй агааржуулах (АС) систем, ослын дохиолол, гал унтраах хэрэгслээр хангах	Лаборатори, шинжлэгч нар, хүрээлэн буй орчны аюулгүй байдлыг хамгаална.	Лабораторийн нөхцөл хангагдаагүй.	Лабораторийн сүлжээний хүрээнд дулаан мэдрэгч систем, шүүлтүүртэй агааржуулах (АС) систем, ослын дохиолол, гал унтраах хэрэгслээр хангасан байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт
	Био-аюулгүй байдлын гарын авлага, САЗ боловсруулан мөрдлөг болгох	Лабораторийн био-аюулгүй байдлыг мөрдөж ажиллах гарын авлага, САЗ заавал байна.	Лабораторийн био-аюулгүй ажиллагааны гарын авлагыг УМЭАЦТЛ-ос Монгол хэл рүү орчуулж, МЭЛ-уд түгээсэн ч	Лабораторийн био-аюулгүй ажиллагааны гарын авлагыг дахин хэвлэж, МЭЛ-ийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, САЗ-ыг шинэчлэн боловсруулж, баталгаажуулан, мөрдөх	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт

			ховордсон; Био-аюулгүй ажиллагааны САЗ байхгүй.		
МЭЛ-удыг Биоаюулгүйн А II ангиллын кабинетаар бүрэн хангах	Лабораторийн барилга нь агааржуулагч сайтай, биоаюулгүйн А II зэрэглэлийн кабинеттай байх.	Ихэнх лабораторид Биоаюулгүйн В II ангиллын кабинет байгаа боловч, А II ангиллынх байхгүй	Биоаюулгүйн А II зэрэглэлийн кабинетыг шинээр нийлүүлж, засвар үйлчилгээг тогтмолжуулж, ХЕПА шүүлтүүрийг сольж байх	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт	
МЭЛ-ийн биоаюулгүйн зэрэглэлийг тогтоох	Лабораторийн биоаюулгүйн зэрэглэлийг тогтоох мэргэжлийн зөвлөл байгуулах	Лабораторийн биоаюулгүйн зэрэглэл тодорхойгүй	МЭЛ-ийн биоаюулгүйн зэрэглэл тогтоогдсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр	
Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авах	Химийн бодис хадгалах тусгай агуулах	Химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөлтэй 1 лабораторитой, 2 лаборатори зөвшөөрөл авахаар баримт бичгүүдээ боловсруулж байна	Сүлжээ лабораториуд химийн бодис ашиглах тусгай зөвшөөрөл авсан байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт	
Биоаюулгүй байдал, биоаюулгүйн эрсдэлийн үнэлгээг тогтмол хийх дадал эзэмшүүлэх	Био-эрсдэлийн менежментийн үнэлгээг хийх	Био-эрсдэлийн менежментийн үнэлгээг лаборатори бүрд хийдэггүй	Био аюулгүй байдал, био-эрсдэлийн менежментийн үнэлгээг жил бүр тогтмол 1-ээс доошгүй хийж байх	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт	
Биоаюултай дээж тээвэрлэх нэгдсэн тогтолцоог бий болгох	А, Б ангиллын халдвартай материалыг илгээхэд савлах, шошголох, баримтжуулахад тавих шаардлагыг хангах, 2 сургагч бэлтгэх	IATA, PI650- Б ангиллын халдвартай материалыг илгээх, PI620-A ангиллын халдвартай материалыг зөвхөн НҮБ-ын Баглах зааварчилгаа (PI620)-д заасны дагуу дээжийг савлаж тээвэрлэж болно.	Улс, аймаг, нийслэл, сум орон нутгаас биоаюултай ачаа, дээж тээвэрлэх журмыг баталж хэрэгжүүлсэн байна; биоаюултай дээж илгээх, тээвэрлэх чиглэлээр 2 сургагч бэлтгэгдсэн байна	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр,	
Хог хаягдлыг зохих журмын дагуу устгадаг болох	Аюултай хог хаягдлыг	Лаборатори бүр аюултай хог хаягдлыг	Эрх бүхий байгууллага /аж ахуйн нэгжээр лабораторийн	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	

		зөөвөрлөх журмыг мөрдлөг болгох	устгах журамтай ч үйл ажиллагаандаа мөрддөггүй.	аюултай хог хаягдлыг тээвэрлэх, халдваргүйжүүлэх, устгах үйл ажиллагааг хэрэгжүүлдэг болсон байна.	
	МЭЛ-ийг аюулгүйн шүршүүр, нүд угаагчаар тоноглох	Олон улсын стандартад нийцсэн аюулгүй орчныг бүрдүүлэх	МЭЛ аюулгүйн шүршүүр, нүд угаагчаар тоноглогдоогүй.	Бүх МЭЛ аюулгүйн шүршүүр, нүд угаагчаар тоноглогдож, ослын үеийн анхан шатны тусламж сайжирч, ажилтныг халдвар болон химийн бодисын хорт нөлөөнөөс хамгаалдаг болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр, Хувийн хэвшлийн санхүүжилт

8.4. Мал эмнэлгийн сүлжээ лаборатори хоорондын хамтын ажиллагаа:

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Санхүүгийн эх үүсвэр
<i>Ерөнхий чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн лабораторийн үндэсний сүлжээг хөгжүүлэх</i>					
<i>Үндсэн чиг үүргийн нэр: Мал эмнэлгийн сүлжээ лаборатори хоорондын хамтын ажиллагааг хөгжүүлэх</i>					
Зорилт-1. Сүлжээ лабораторийн мэргэшлийн нэгдсэн удирдлага, хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх.	МЭЛ-удын шатлалын дагуу дээрээс доош чиглэсэн мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах эрх зүйн орчныг боловсронгуй болгох	Сүлжээ лабораториуд нэгдсэн тогтолцоонд орж, шатлан удирдах эрх зүйн өөрчлөлт шинэчлэл хийгдсэн байх	Сүлжээ лабораториудыг мэргэшлийн нэгдсэн удирдлагаар хангах тогтолцоо бүрдээгүй, МЭЛ-уд нь аймаг, нийслэлийн МЭГ-т шууд харьяалагддаг, мэдээ тайлан нь УМЭАЦТЛ-т нэгтгэдэггүй	Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн ажиллах журмын хэрэгжилтийг хангах, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг болсон байна.	Улсын төсөв
	МЭЛ-удын жил бүр хамтын ажиллагааны гэрээ байгуулж, ажлын үр дүнг тооцох, урамшууллын болон хариуцлагын арга хэмжээ авч хэвших.	Лаборатори хоорондын үйл ажиллагаа идэвхжин, хамтын ажиллагаа сайжран, ахиц дэвшил гарч үр дүн өмнөх оноос өссөн байх	Өнөөгийн байдлаар зөвхөн гоц халдварт, зооноз өвчний тандалт шинжилгээ хийх гэрээ байгуулж, мэргэжил арга зүйн	МЭЛ-уд хамтын ажиллагааны гэрээ байгуулж, хагас жил, жилийн эцэст ажлын гүйцэтгэл үр дүнг	Улсын төсөв

			удирдамжаар хангаж ажилладаг, ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, хариуцлага тооцох механизм бүрдээгүй. Лабораторийн жилийн үйл ажиллагааны үр дүнг улсын хэмжээнд үнэлж, дүгнэдэггүй, шагнал урамшуулал, хариуцлагын систем нэвтрээгүй	тооцох хариуцлагын тогтолцоо бий болсон байна. УМЭАЦТЛ нь аймаг, нийслэлийн МЭЛ-ийн жилийн ажлыг үнэлж дүгнэх журам гаргаж, хэрэгжилтийг хангаж ажилладаг болсон байна.	
	МЭЛ-ийн үйл ажиллагаанд 2 жил тутам лаборатори үнэлэх арга (ЛҮА (LMT))-аар үнэлгээ хийж, дүгнэлт гарган үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах арга хэмжээ авах	Лабораторийн чадавх жигд сайжирч, үнэлгээний дүн 2021 оны үнэлгээ (30%)-ээс нэмэгдэж аймаг, нийслэлийн лаборатори 50%-ас дээш, УМЭАЦТЛ 70%-аас дээш үнэлгээтэй болох	2016, 2021 онд ЛҮА-аар 2 удаа үнэлгээ хийсэн. Үнэлгээний дүн нийтлэг түвшинд хангалтгүй байсан.	Мал эмнэлгийн сүлжээ лабораториудад 2 жил тутамд ЛҮА-аар үнэлгээ хийж, үр дүнг тооцон, сул талуудыг сайжруулах арга хэмжээ авдаг болсон байна.	Улсын төсөв
Зорилт-2. Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний тандалт судалгаа, баталгаажуулах шинжилгээг хамтран гүйцэтгэх	Мал, амьтны гоц халдварт болон халдварт өвчний зорилтот тандалт шинжилгээнд сорьц авах, шинжилгээ хийх үйл ажиллагааг лабораториуд гэрээгээр гүйцэтгэх	Шинжээч нарын ур чадвар сайжирч, ажлын ачаалал тэнцвэржих	Шүлхий, БММӨ, Бруцеллёзын тандалтын хүрээнд УМЭАЦТЛ, аймаг, нийслэлийн МЭЛ-той жил бүр гэрээ хийн, тандалт шинжилгээг хамтарч хэрэгжүүлдэг.	Малын гоц халдварт болон халдварт өвчний цар хүрээг тогтоох, дархлаажуулалтын үр дүнг хянах, эрсдэлийн үнэлгээ хийх төлөвлөгөөг жил бүр боловсруулан, хэрэгжүүлдэг болсон байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Мал, амьтны гоц халдварт /хил дамжин халдварладаг өвчин (Шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах өвчин,	Мал, амьтны гоц халдварт /хил дамжин халдварладаг өвчин (Шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах	Мал, амьтны гоц халдварт /хил дамжин халдварладаг өвчин (Шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах	Мал, амьтны гоц халдварт /хил дамжин халдварладаг өвчин (Шүлхий,	Мал, амьтны гоц халдварт /хил дамжин халдварладаг

	африкийн адууны өвчин, гахайн африкийн мялзан, шувууны томуу г.м.) оношилгооны бэлэн байдлыг хангах	өвчин, африкийн адууны өвчин, гахайн африкийн мялзан, шувууны томуу г.м.) -ийг оношлох цомгийн нөөцийг бүрдүүлэх	мялзан, үхрийн арьс товруутах өвчин, африкийн адууны өвчин, гахайн африкийн мялзан, шувууны томуу г.м.)-ийг оношлох цомгийн нөөц хангалтгүй	өвчин (Шүлхий, мялзан, үхрийн арьс товруутах өвчин, африкийн адууны өвчин, гахайн африкийн мялзан, шувууны томуу г.м.) ийг оношлох цомог (тус бүр 20-ос цөөнгүй цомог)-ийн нөөцтэй болсон байна.	
	МЭЛ-ийн шинжээч нар нь мал, амьтны өвчнийг судлах, судалгааны ажил явуулах, илтгэл хэлэлцүүлэх, өгүүлэл бичиж нийтлүүлэх, магистр, докторын зэрэг хамгаалах	МЭЛ-ийн шинжээч нарын 30-аас дээш хувь нь магистрын зэрэг хамгаалж, мэргэшлийн зэрэг авсан байх	МЭЛ-ийн шинжээч нар судалгааны ажил хийх, өгүүлэл нийтэлж, илтгэл хэлэлцүүлэх нь хангалтгүй байна.	Судалгааны ажлын төсөл хэрэгжүүлж, шинжээч нарыг хамруулах.	
Зорилт-3. лабораторийн цахим мэдээллийн систем (ЛЦМС) -ийг хөгжүүлж, сүлжээ лабораторийг системд бүрэн хамруулах, үр дүнтэй, шинжлэх ухааны үндэслэлтэй өвчний мэдээллийн баазыг бий болгох	МЭЛ-ийг нэгдсэн цахим системд нэгтгэж, шинжилгээний гүйцэтгэл, үр дүнг хянах	МЭЛ-ийн нэгдсэн цахим системд бүгд холбогдсон байна.	МЭЛ-ийн цахим системд УМЭАЦТЛ, МЭЭСБУЛ, МЭЛ-уд нэгдэж эхлээгүй. Сум, дүүрэг, хүнсний зах, махны үйлдвэрийн лабораториуд холбогдоогүй байна.	МЭЛ-дийн үр дүнг цахим системээр хянаж, баталгаажуулдаг болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	ЛММС-д сүлжээ лабораториудын ажлын байр, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, оношлуур, хүний нөөцийн судалгаа, оношилсон өвчний мэдээллийг тус тус оруулж мэдээллийн санг өргөжүүлэн хөгжүүлэх.	ЛММС-д оруулсан мэдээллийн төрөл, тоо шинэчлэл (update) хийсэн давтамжаар тодорхойлно	Нэгдсэн цахим мэдээллийн системд дээж бүртгэл, тандалтын судалгаа, шинжилгээний тайлан, дүнгийн хуудаснаас өөр мэдээлэл ороогүй байна.	МЭЛ-ийн бүх мэдээллийг цахим санд нэгтгэж, жил бүр шинэчлэл хийдэг болсон байна.	Улсын төсөв, төсөл, хөтөлбөр
	ЛММС-ийн бүх хэрэглэгчдэд зориулсан мэдээллийн буцаах урсгал боловсруулж, баталгаажуулах	ЛММС-ийн мэдээллийн урсгалын СА3-удыг боловсруулж, албажуулан, мөрдөнө.	Мэдээллийн урсгалын СА3 байхгүй	Нэгдсэн цахим системийн мэдээллийн урсгалын СА3-ыг боловсруулан	Улсын төсөв

				баталгаажуулснаар мэдээллийн урсгал тодорхой, ил тод болсон байна.	
ЛММС-ийн нууцлал, аюулгүй байдал сайжруулах, тогтвортой байдлыг хангах, хэрэглээг өргөжүүлэх	ЛММС-д оруулсан мэдээллийн нууцлалыг хангах, Android, IOS үйлдлийн системд тохирох нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангасан олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн системийг хөгжүүлнэ.	Мэдээллийн аюулгүй байдал хангагдаагүй, сервер, архивын нэгдсэн сан байхгүй, Үндэсний дата төвд сервер суурилагдаагүй.	Нэгдсэн цахим системийн нууцлал, аюулгүй байдал сайжирч, тогтвортой болж, хэрэглээ нь өргөжиж, Үндэсний дата серверт суурилагдан, архивын нэгдсэн сантай болсон байна	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	
ЛММС-ийг судлаач нар ашиглах боломж, үр дүнгээс хэвлэн нийтлүүлэх байдал	ЛММС-ийг судлаач нар ашиглан, үр дүнгээс нь хэвлэн нийтлүүлэх боломжийг бүрдүүлнэ	Цахим системийг зөвхөн МЭЕГ-ын зарим мэргэжилтэн болон лабораториуд хэрэглэж байгаа	Нэгдсэн цахим мэдээллийн систем ашиглалтын үр дүнтэй болж, түүний өгөгдлийг агуулсан эрдэм шинжилгээний бүтээлүүд олон улсын сэтгүүлүүдэд хэвлэгддэг болно.	Улсын төсөв	
ЛММС-ийг олон улсын түншлэгч талуудын мэдээллийн систем болон бусад бүс буюу өвчин мэдээллийн олон улсын системүүдтэй холбох	Өвчний мэдээллийг автоматаар олон улсын түншлэгч талуудад илгээдэг болно	Одоогийн байдлаар холбогдоогүй байна	Өвчний мэдээлэл олон улсын түншлэгч талуудад нээлттэй болсон байна.	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	
Лабораторийн нэгдсэн цахим системийн өгөгдлийн оролт, гаралтыг цахим болон цаасан хэлбэрээр баримтжуулан	Архив бичиг хэргийн тухай хууль, журмыг дагаж мөрдөнө.	Архив зөвхөн программ зохиосон компанийн серверт хадгалагдаж байгаа	Цахим системийн өгөгдлийн мэдээллийн архивын нэгжийг	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	

	архивлах Мал эмнэлгийн сүлжээ лабораторийн албан ёсны эрхтэй нэгдсэн веб сайт, page хуудас нээж ажиллуулах.	Сүлжээ лабораторийн веб сайт, page хуудасны хандалтыг нэмэгдүүлэх	Сүлжээ лабораторийн албан ёсны нэгдсэн цахим хуудас байхгүй.	бүрдүүлсэн байна. Сүлжээ лабораторийн албан ёсны эрхтэй нэгдсэн веб сайт, page хуудас нээж, лабораториуд мэдээллээ солилцох, нууцын зэрэглэлгүй мэдээллийг веб сайт, page хуудсаараа дамжуулан олон нийтэд хүргэдэг болсон байна	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
--	--	---	--	---	-----------------------------

Ес. Санхүүжилт эх үүсвэрээр:

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт хөрөнгийн хэмжээ (тэрбум/төг)	Төсөв			
			2021 он	2022 он	2023 он	2024 он
1	Улсын төсөв	7.5	1.5	1.5	2.0	2.5
2	Гадаад зээл, тусламж	3.7	0	1.7	2.0	0
3	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	10.5	0	0.5	5.0	5.0
4	Гадаад зээл, тусламж, Хөгжлийн банк	3.5	3.5	0	0	0
5	Бусад эх үүсвэр	0	0	0	0	0
Нийт		25.2	5	3.7	9	7.5

АРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

Төрийн болон төрийн бус байгууллага хамтран тус стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд жил бүр үнэлгээ хийж, шалгуур үзүүлэлт тус бүрийн хүрсэн түвшнийг тогтооно.

Үнэлгээний дүнг жил бүрийн 1 дүгээр сард багтаан сайдын зөвлөлийн хуралдаанд танилцуулах, олон нийтэд мэдээлэх, хамтран ажилладаг байгууллагуудтай мэдээлэл солилцох, гарсан дүгнэлтийг дараа жилийн үйл ажиллагааны төлөвлөлтөд ашиглах арга хэмжээг зохион байгуулахын зэрэгцээ бүс нутаг, дэлхийн хэмжээний хурал, уулзалт, зөвлөгөөнд оролцож, мэдээлэл, туршлага солилцоно. Шаардлагатай тохиолдолд олон улсын болон дотоодын холбогдох байгууллага, мэргэжлийн шинжээчдээр хөндлөнгийн үнэлгээ хийлгэнэ.

Хавсралт 1. Аймгуудын МЭЛабораторийн барилга байгууламжийн өнөөгийн байдал

НЭГ. БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ

- 1.1. Архангай, Өмнөговь аймгууд 2020 онд баригдсан шинэ байртай болсон 2 аймаг байна.
- 1.2. Хуучин барилга байгууламжтай 14 аймаг байна. Ашиглалтад орсон хугацаа харилцан адилгүй ба 1940-1995 онд баригдсан 26-81 жилийн насжилттай байна.
- 1.3. Зориулалтын бус байртай 2 аймаг байна. Говьсүмбэр аймаг нийтийн орон сууцанд байрладаг бол Орхон аймаг Нутгийн захиргааны 3-р байранд байрладаг, стандартын бус байгууламжтай байна.
- 1.4. МХГ-ын дүгнэлт гарч актлагдсан, ашиглагдах боломжгүй болсон байртай 2 аймаг байна. Үүнд: Баянхонгор, Хөвсгөл аймаг байна. Хөвсгөл аймгийн байр нь газар хөдлөлтөөс хана цуурсан, доош суулт өгсөн, зарим газар нь тулгуур хийсэн нурах аюултай болсон байна.
- 1.5. Хөвсгөл аймгийн МЭЛабораторийн байрны талаар гарсан МХГ-ын барилгын хяналтын улсын байцаагийн 2014 оны 04-р сарын 17-ны өдрийн 28-07-023/213 тоот дүгнэлт гарсан байна.
- 1.6. Баянхонгор аймгийн МЭЛабораторийн барилга байгууламжийн талаар МХГ-ын 2 дүгнэлт байна. Үүнд: 1. 2015 оны 06-р сарын 09-ний өдрийн 05-07-003/80 тоот дүгнэлт */Барилгын хяналтын улсын байцаагч /*
- 1.7. 2015 оны 05-р сарын 11-ийн өдрийн 05-03-009/68 тоот дүгнэлт */Эрүүл ахуй халдвар судлалын хяналтын улсын байцаагийн дүгнэлт /агаарт хөгцтэй/*
- 1.8. Дархан-Уул аймаг нь өөрийн гэсэн байргүй одоо ХХААГ-ын байрны нэг давхарт МЭЛаборатори болон албан контор нь нэг дор байрлаж байгаа
- 1.9. 16 аймгийн МЭЛаборатори нь 26-80 жилийн насжилттай иж бүрэн засвар үйлчилгээ хийгдээгүй

ХОЁР. БАЙРШИЛ

- 2.1. Аймгуудын МЭЛабораторийн байршил нь анх баригдахдаа аймгийн төв цэгээс 3-5 км зайд баригдсан боловч одоогийн байдлаар Дархан-Уул, Сэлэнгэ, Орхон, Говьсүмбэр зэрэг аймгуудаас бусад аймгуудын байр нь айл хорооллын дунд оршиж байна. Энэ нь тухайн аймгийн хот төлөвлөлт, шинээр баригдаж байгаа гэр хороололд газар олголтой холбоотой байна.

ГУРАВ. ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭ

- 3.1. Шинэ байртай болсон 2 аймгаас бусад аймгуудын МЭЛабораторийн байранд 2006-2016 оны хооронд урсгал засвар, дээврийн засвар хийгдсэн боловч их засвар хийгдээгүй, ихэнх барилгууд насжилттай, цаашид иж бүрэн их засвар хийх шаардлагатай болсон байна.

ДӨРӨВ. УСАН ХАНГАМЖ

- 4.1. Цэвэр усны төвлөрсөн шугамд холбогдсон 18 аймаг буюу 81,8 хувь усан хангамжаар сайн хангагдсан байна.
- 4.2. Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ аймгууд МЭЛабораторийн хажууд өөрийн гэсэн гүний худагтай ба түүнээс цэвэр усны хэрэгцээг хангадаг байна.
- 4.3. Бохирын төвлөрсөн шугамд холбогдсон 18 аймаг буюу 81,8 хувь нь шаардлага хангаж байна. Дорнод, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ аймгууд хашаандаа бохирын худагтай байна.
- 4.4. Баян-Өлгий, Хэнтий аймгууд огт бохирын шугам байхгүй байна.

ТАВ. ХАЛААЛТ, ДУЛААН

- 5.1. Төвийн халаалтын шугамд холбогдсон 18 аймаг буюу 81,8 хувь халаалтын асуудлаа бүрэн шийдсэн байна.

- 5.2. Өвөрхангай, Сүхбаатар, Хэнтий, Сэлэнгэ аймгууд тустай уурын зуух болон нам даралтын зуухаар халаалтаа авдаг байна.

ЗУРГАА. ХАШАА, ХАРУУЛ ХАМГААЛАЛТ

- 6.1. Орхон, Говь-сүмбэрээс бусад бүх аймгууд буюу 90,9 хувь нь өөрийн гэсэн хашаагаар тусгаарлагдсан байна.
- 6.2. Архангай, Булган, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Сэлэнгэ, Баянхонгор зэрэг 7 аймаг хашаандаа байрладаг байнгын сахиултай байна.
- 6.3. Бусад аймгууд 24 цагаар ээлжлэн хардаг жижүүртэй байна. /ХХААХҮСайдын тушаалаар гэрээт ажилчдын орон тоог байхгүй болгосонтой холбоотой жижүүр, сахиул, галч нарын асуудлыг эргэж харах. Мал эмнэлэг бол улсын онцгой байгууламж ба харуул, хамгаалалтгүй байж хэрхэвч болохгүй !!!! /
- 6.4. Архангай, Өмнөговь аймаг гадна болон дотор талдаа бүрэн камержуулсан байна.
- 6.5. Зөвхөн байгууламжийн гадна тал, орох хэсэг, коридорыг камержуулсан 12 аймаг байна. Харин лабораторийн шинжилгээ хийдэг өрөөнүүдэд камержуулалт хийгдээгүй байна.
- 6.6. Камержуулалт хийгдээгүй 8 аймаг байна.

ДОЛОО. АГААРЖУУЛАЛТ

- 7.1. Архангай, Өмнөговь аймгийн МЭЛабораторийн агааржуулалт шаардлага хангасан байна.
- 7.2. Аж ахуйн аргаар өөрсдөө агааржуулалт хийсэн 11 аймаг байна. Энэ нь төмөр, хуванцар хоолойг хооронд нь холбож үзүүрт вентилятор суурилуулан агааржуулалт хийсэн байна.
- 7.3. Говьсүмбэр, Дорнод, Дорноговь, Дундговь, Төв, Увс, Ховд, Хөвсгөл, Баянхонгор зэрэг 9 аймаг огт агааржуулалтгүй байна.

НАЙМ. УСТГАЛЫН НҮХ

- 8.1. Нийт 15 аймаг хашаандаа устгалын нүхтэй байна.
- 8.2. Дархан-Уул, Говьсүмбэр, Орхон аймгууд төвлөрсөн хогийн цэгт аюултай хог хаягдал, эм эмнэлгийн хэрэгсэл устгах зориулалтын нүхэнд зөөвөрлөн устгал хийж байна.
- 8.3. Төв, Хөвсгөл, Хэнтий, Баянхонгор зэрэг 4 аймаг устгалын цэг байхгүй

ЕС. ШАТААХ ЗУУХ

- 9.1. Шатаах зуухтай 10 аймаг байна. Гэвч ихэнх зуух аж ахуйн аргаар хийгдсэн, зориулалтын бус байна.
- 9.2. Бусад аймгуудад шатаах зуух байхгүй байна.

ДҮГНЭЛТ:

1. Хөвсгөл, Баянхонгор, Орхон, Дархан, Говьсүмбэр аймгийн МЭЛабораторийг шинээр барих
2. Архангай, Өмнөговь, Дорноговь, Сэлэнгэ аймгаас бусад бүх аймгуудын МЭЛабораторийг байранд их засвар хийх / агааржуулалт, цэвэр бохир ус, сантехникийн шугам, хоолой, усгалын нүх г.м /
3. МЭЛабораторийн орчин, нөхцөлийг сайжруулах, камержуулалтын асуудлыг Архангай, Өмнөговь аймгаас бусад бүх аймгуудад иж бүрэн шинэчлэх, шинжилгээний өрөө, тасалгааг кодын түгжээтэй болгох

Хавсралт 2. Аймгуудын МЭЛабораторийн тоног төхөөрөмжийн өнөөгийн байдал

	Тоног төхөөрөмж	ПГУ машин	Елиза уншигч	БАКабинет	Автоклав	Термостат	Центрифуг	Элендорф пипетик 1-10мкр		Ус нэрэгч		Микроскоп		Хөргөх төхөөрөмж		
	Аймаг							Нэг сувагт	Олон сувагт	Энгийн	Даавар	Дэлгэцтэй	люминисценц	Хөргүүр	Хөргөгч	Хөлдөөгч
1	Архангай	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
2	Баян-Өлгий	зас	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
3	Баянхонгор	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
4	Булган	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
5	Говь-Алтай	+	+	Ху	Ху	Ху	+	+	+	+	+	-	+	+	+	+
6	Говьсүмбэр	аш	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
7	Дархан-Уул	Ху	Ху	Ху	Ш/А	Ху	Ху	+	Ш/А	Ш/А	Ш/Х	Ш/А	Ш/Х	+	+	+
8	Дорнод	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
9	Дорноговь	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
10	Дундговь	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
11	Завхан	зас	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А	-		Ш/А	+	+	+	+
12	Орхон	+	+	+	+	Ху	+	+	Ш/А	+	Ш/А	Ш/А	Ш/Х	+	+	+
13	Сүхбаатар	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А		-	-	-	+	+	+
14	Сэлэнгэ	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
15	Өвөрхангай	+	Ху	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А	+	-	Ш/А		+	+	+
16	Өмнөговь	+	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
17	Төв	зас	+	Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		+	+	+
18	Увс	+	+	+	Ху	Ху	+	+	Ш/А			Ш/А		Ш/А	Ш/А	+
19	Ховд	Ху	Ху	Ш/Х	+	Ш/Х	Ш/Х	Ш/А	Ш/А	Ху	-	Ш/А	Ху	Ху	+	Ху
20	Хөвсгөл	зас		Ш/Х	Ху	Ху	+	+	Ш/А	-	-	-	+	+	+	+
21	Хэнтий															

+ байгаа, - байхгүй, Ху- хуучин, Ш/Х- шаардлага хангахгүй, Ш/А- шинээр авах шаардлагатай